

“ГОЛОМТ БАНК” ХК-ИЙН 2025 ОНЫ 4-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН НИЙТЛЭГДЛЭЭ

Монгол Улс, Улаанбаатар хот - (2026.01.19) “Голомт Банк” ХК-ийн 2025 оны 4-р улирлын санхүүгийн тайлан нийтлэгдлээ.

2025 оны 2-р хагас жилд бизнесийн орчинд нөлөө үзүүлсэн гол макро-эдийн засгийн үзүүлэлтүүдийг дурдвал:

- 2025 оны хоёрдугаар хагас жилийн байдлаар уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтөд хүчтэй дэмжлэг үзүүлээ. Нүүрсний үнэ өмнө онтой харьцуулахад буурсан ч экспортын биет хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдсэний үр дүнд олборлолт сэргэж, салбарын үйлдвэрлэлийн идэвх дээшиллээ.
- Ийнхүү 2025 оны 11-р сарын байдлаар Монгол Улсын эдийн засаг 5.9%-аар тэлэв. Энэхүү өсөлтөд малын хэвийн бус хорогдлыг түүхэн доод түвшинд хадгалснаар хөдөө аж ахуйн салбар 2025 онд эдийн засгийн өсөлтийн тулгуур болж чадлаа.
- ОУВС-ын үзэж байгаагаар дэлхийн инфляцын түвшин буурах чиг хандлагатай байгаа бол Монгол Улсын хувьд цахилгааны үнийн өсөлтийн суурь нөлөөлөл арилсантай холбогдуулан 12-р сард инфляц Монголбанкны зорилтот интервалын түвшинд хүрч 7.5%-тай гарав.
- 2025 оны 2-р хагас жилийн байдлаар нийт экспорт 15.7 тэрбум ам.доллар, импорт 11.3 тэрбум ам.доллар гарч гадаад худалдааны тэнцэл ашигтай байна. Мөн 11-р сарын байдлаар төлбөрийн тэнцэл 65.7 сая ам.долларын ашигтай гарлаа.
- Ингэснээр Монгол Улсын гадаад валютын нөөц 7 тэрбум ам.доллар байгаа нь ханшийн тогтвортой байдалд голлон нөлөөлж байна.

Голомт банкны 2025 оны олон улсын хөрөнгийн зах зээл, санхүүгийн байгууллагуудаас татсан эх үүсвэр:

- Голомт банк Япон улсын томоохон институцийн хөрөнгө оруулагчдаас өрийн хэрэгслээр дамжуулан 100 сая ам.доллартой тэнцэхүйц иенийг татан төвлөрүүллээ.
- 2025 оны байдлаар Олон улсын санхүүгийн байгууллагуудаас Банк нийт 230 сая ам.долларын санхүүжилт татан төвлөрүүлсэн бөгөөд үүний зэрэгцээ хөрөнгийн зах зээлээс 150 сая ам.доллартой тэнцэх хэмжээний эх үүсвэр, мөн худалдааны санхүүжилтийн шугамаар 43.3 сая ам.доллар тус тус татан төвлөрүүлээд байна.

Голомт банкны 2025 оны 4-р улирлын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг өмнөх онтой харьцуулахад:

- Нийт зээлийн багц 805.2 тэрбум төгрөг буюу 10.8%-аар тэлж, 8.3 их наяд төгрөгт хүргэв.
- Чанаргүй зээлийн харьцаа 3 хувиас 0.5 хувиар буурч, 2.5%-д хүргэн сайжирч, салбарын дундаж үзүүлэлтээс бага үзүүлэлттэй байна.
- Нийт актив 3.6 их наяд төгрөг буюу 23.4%-аар өсөж 19 их наяд төгрөгт хүрэв.
- Нийт өөрийн хөрөнгө 22.8%-аар өсөж, 1.6 их наяд төгрөгт хүрэв.
- Харилцагчийн эх үүсвэр 1.3 их наяд төгрөг буюу 15.6%-аар өсөж 10 их наяд төгрөгт хүрэв.
- Хөрөнгө оруулалтын багц 25.3%-аар өсөж, 1.6 их наяд төгрөгт хүрэв.
- Татварын дараах цэвэр ашиг 345.1 тэрбум төгрөгт хүрч жилээр илэрхийлсэн дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 24.3%-д хүрлээ.
- Монголбанк болон Олон Улсын санхүүгийн байгууллагуудаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.

Хөрөнгө оруулагчдадаа зориулан Голомт банкны удирдлагууд сүүлийн тайлант жилийн санхүүгийн үр дүн болон цаашдын төлөвийн талаар хэлэлцэх “Earnings call” болон асуулт, хариултын (Q&A) шууд дамжуулалтыг өөрсдийн цахим сувгаар 2026 оны 2-р сарын 05-ны өдөр зохион байгуулна.

“Голомт банк” ХК компани 2025 оны 4-р улирлын санхүүгийн тайлангаа Хөрөнгө оруулагчдын харилцааны цахим хуудсанд байршуулан нийтэллээ.

Тайлантай танилцахыг хүсвэл [ЭНД](#) дарж зочилно уу.